



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

### Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журам батлах тухай

Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах журмыг нэгдүгээр, Төрийн албан хаагчийн төлөөллийн сонгон шалгаруулалтын үнэлгээний хуудсыг хоёрдугаар, Комиссын гишүүний баталгааг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэ тогтоолыг 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ЛҮНДЭЭЖАНЦАН



Монгол Улсын Их Хурлын Төрийн  
байгуулалтын байнгын хорооны 2018 оны  
10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

## ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨӨЛЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

УХД0316

1.1. Энэ журмаар Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 68 дугаар зүйлийн 68.2-т заасны дагуу төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулж, Төрийн албаны зөвлөл (цаашид “Зөвлөл” гэх)-ийн гишүүнд нэр дэвшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэ журмын зорилго нь Зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан төрийн албан хаагчийг сонгон шалгаруулж, түүнийг Зөвлөлийн гишүүнээр томилуулахаар Монгол Улсын Их Хуралд нэр дэвшүүлэхэд оршино.

1.3. Төрийн албан хаагчийн төлөөллөөс нэр дэвшиж томилогдох Зөвлөлийн гишүүний сул орон тоотой тэнцүү тооны төрийн албан хаагчийг энэ журмын дагуу нэр дэвшүүлнэ.

1.4. Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулахад дараах зарчмыг баримтална:

- 1.4.1. хууль дээдлэх;
- 1.4.2. шударга ёсыг баримтлах;
- 1.4.3. аливаа нөлөөллөөс ангид байх;
- 1.4.4. ил тод байх;
- 1.4.5. ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.

1.5. Төрийн албан хаагчийн төлөөлөл гэж Зөвлөлийн гишүүнд тавих шаардлагыг хангасан бөгөөд комиссын сонгон шалгаруулалтаар нэр дэвшүүлэхээр шалгаруулсан төрийн албан хаагчийг хэлнэ.

### Хоёр. Нэр дэвшигчид тавих шаардлага

2.1. Энэ журмын дагуу Зөвлөлийн гишүүнд нэр дэвшигч нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2.1.1. дээд боловсролтой;
- 2.1.2. дөчин таван нас хүрсэн;
- 2.1.3. төрийн жинхэнэ албан тушаалд 15-аас доошгүй жил ажилласан, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд дөрвөөс доошгүй жил ажилласан;
- 2.1.4. төрийн удирдлага, эдийн засаг, эрх зүй, боловсролын чиглэлээр мэргэшсэн;
- 2.1.5. ял шийтгүүлж байгаагүй;
- 2.1.6. сүүлийн нэг жилийн хугацаанд улс төрийн намын аль нэг байгууллагад сонгуулт болон бусад албан тушаал эрхэлж байгаагүй;
- 2.1.7. сахилгын шийтгэлээр төрийн албанаас халагдаж байгаагүй.

2.2.Энэ журмын 2.1.4-т заасан тухайн чиглэлээр мэргэшсэн гэдэгт бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий албан тушаалд дөрвөөс доошгүй жил ажилласан буюу тухайн мэргэжлийн чиглэлээр зургаан сараас дээш хугацааны сургалтад хамрагдсан нь гэрчилгээгээр баталгаажсан байхыг ойлгоно.

**Гурав.Сонгон шалгаруулалтыг зарлан мэдээлэх,  
нэр дэвшүүлэх**

3.1.Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлтээ ирүүлсэн төрийн албан хаагч (цаашид “оролцогч” гэх)–ийг бүртгэх хугацаа, байршил, нэр дэвшигчид тавих шаардлага, бүрдүүлэх баримт бичиг зэргийн талаар бүртгэл эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө Зөвлөлөөс олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл болон Зөвлөлийн цахим хуудсаар нийтэд зарлан мэдээлнэ.

3.2.Бүртгэл явуулах байр, хугацааг өөрчлөх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд сонгон шалгаруулах комисс тухай бүр мэдээлнэ.

3.3.Сонгон шалгаруулалтад төрийн албан хаагч нэрээ дэвшүүлэх эрхтэй. Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл төрийн албан хаагчийг нэр дэвшүүлж болно.

3.4.Оролцогч дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

3.4.1.төрийн албан хаагчийн анкет;

3.4.2.сонгон шалгаруулалтад бүртгүүлэхээр бичгээр гаргасан хүсэлт;

3.4.3.иргэний үнэмлэхийн хуулбар, эх хувийн хамт;

3.4.4.төрсний гэрчилгээ, түүнтэй адилтгах баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт;

3.4.5.их, дээд сургууль төгссөн гэрчилгээний хуулбар, эх хувийн хамт;

3.4.6.нийгмийн даатгалын дэвтэр болон ажил эрхлэлтийг тодорхойлох бусад баримт бичгийн хуулбар, эх хувийн хамт;

3.4.7.мэргэшүүлэх сургалтад хамрагдсаныг баталгаажуулсан гэрчилгээ;

3.4.8.энэ журмаар Зөвлөлийн гишүүнд тавих шаардлага, ур чадварын талаар гаргасан тайлбар, нотлох баримт;

Жич:Ур чадварыг эзэмшсэн талаарх тайлбарт төрийн албанд ажиллахдаа энэ журмын 6.8-д заасан гурван төрлийн ур чадварыг ашиглан тулгамдсан ямар асуудлыг шийдвэрлэхийн тулд ямар арга хэмжээг авч хэрэгжүүлсэн, улмаар ямар үр дүнд хүрсэн талаар тодорхой баримттай тусгана.

3.4.9.төрийн албаны холбогдолтой судалгааны ажил, эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт.

**Дөрөв.Сонгон шалгаруулах комисс**

4.1.Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах комиссыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны Ажлын алба, Төрийн албаны

зөвлөлийн Ажлын алба, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Ажлын алба, Жендэрийн үндэсний хорооны Ажлын алба, Засгийн газрын харьяа төрийн албаны сургалтын байгууллага, Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газраас төрийн албанд хамгийн олон жил ажилласан удирдах албан тушаалтан долоон хүний бүрэлдэхүүнтэйгээр Төрийн байгуулалтын байнгын хорооны шийдвэрээр байгуулна.

4.2. Комиссын гишүүн сонгон шалгаруулалтыг аливаа хөндлөнгийн нөлөөнд автахгүй ажиллах талаар баталгаа гарган гарын үсэг зурж, Төрийн байгуулалтын байнгын хороонд хүлээлгэн өгнө.

4.3. Комиссын гишүүн оролцогчдын талаар санал, дүгнэлт гаргах болон үнэлгээ өгөхөд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан ашиг сонирхлын зөрчил үүсэхээр байвал энэ талаар мэдэгдэж санал, дүгнэлт гаргах, үнэлгээ өгөхөд оролцохгүй.

4.4. Комисс дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.4.1. сонгон шалгаруулалтад оролцогчийн бурдуулсэн баримт бичгийг хүлээн авах, хянах;

4.4.2. шаардлагатай тохиолдолд нэмэлт тодруулга авах;

4.4.3. оролцогч шаардлага хангаж байгаа эсэх талаар холбогдох баримтад тулгуурлан санал, дүгнэлт гаргах;

4.4.4. энэ журамд заасан аргачлалын дагуу оролцогчид үнэлгээ өгөх;

4.4.5. сонгон шалгаруулалтын дүнг хуралдаанаараа хэлэлцэж, шалгарсан төрийн албан хаагчийн талаарх мэдээллийг Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлэх;

4.4.6. сонгон шалгаруулалтын материалыг зохих журмын дагуу Улсын Их Хурлын Тамгын газрын архивт хүлээлгэн өгөх.

4.5. Комиссын ажиллах нөхцөлийг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба хангаж, дэмжлэг үзүүлнэ.

#### **Тав.Оролцогчдыг бүртгэх**

5.1. Сонгон шалгаруулалтад нэрээ дэвшүүлсэн оролцогч энэ журмын 2.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар комисс санал, дүгнэлт гаргаж шаардлага хангасан оролцогчдыг бүртгэнэ.

5.2. Зөвлөлийн гишүүнээр томилогдон ажиллаж байгаа гишүүнтэй нэг нутгийн, нэг анги хамт төгссөн, хамаарал бүхий оролцогчийг бүртгэхгүй.

5.3. Оролцогчийг бүртгэх тухай шийдвэрийг комисс хуралдаанаараа гаргах ба шаардлага хангаагүй албан хаагчдад энэ тухай шалтгааныг мэдэгдэнэ.

5.4. Сонгон шалгаруулалтад бүртгээгүйтэй холбоотой гомдлыг тухайн албан хаагч ажлын нэг өдрийн дотор гаргаж болох бөгөөд энэ тохиолдолд комисс уг гомдлыг ажлын гурван өдрийн дотор хянаж эцэслэн шийдвэрлэнэ.

## **Зургаа.Сонгон шалгаруулалт явуулах**

6.1.Сонгон шалгаруулалтыг Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн З дугаар зүйлийн 3.1.3-т заасан чадахуйн /мерит/ зарчимд тулгуурлан оролцогчийн мэдлэг, боловсрол, мэргэшил, туршлага, мэргэжил, ур чадварыг үнэлэх замаар явуулна.

6.2.Сонгон шалгаруулалтын үнэлгээгээр оролцогчдын мэдлэг, боловсролын түвшинд 30 хүртэл оноо, төрийн албаны мэргэшил, туршлагад 40 хүртэл оноо, мэргэжил, ур чадварт 30 хүртэл оноо, ярилцлагад 20 хүртэл оноо өгч, нийт онооны нийлбэрийн дарааллаар жагсаалт гаргана.

6.3.Комисс оролцогчийн мэдлэг, боловсролын түвшинг үнэлэхдээ доорх хүснэгтэд үзүүлсэн оноог өгнө:

Боловсролын зэрэг	Бакалавр	Магистр	Доктор
Оноо	10	20	30

6.4.Мэдлэг, боловсролыг үнэлэхдээ оролцогчийн хамгийн дээд түвшинд харгалзах оноо өгнө.

6.5.Комисс оролцогчийн төрийн албаны мэргэшил, туршлагын үнэлгээг түшмэлийн ангилал тус бүрд ажилласан жилийг (сарыг жилд шилжүүлнэ) дараах хүснэгтэд үзүүлсэн коэффициентээр үржүүлж тэдгээрийн нийлбэрээр гаргана.

Ажилласан албан тушаалын ангилал	Туслах түшмэл	Дэс түшмэл	Ахлах түшмэл	Эрхэлсэн түшмэл	Тэргүүн түшмэл
Оноо	1	1.2	1.4	1.6	1.8

6.6.Хэрэв оролцогч төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан бол тухайн ажилласан жилийг тэргүүн түшмэлийн ангилалд хамааруулж тооцно.

6.7.Мэргэшил туршлагын хамгийн дээд үнэлгээний онооны нийлбэр дүн нь 40-өөс хэтрэхгүй байна.

6.8.Мэргэжил, ур чадварт үнэлгээ өгөхдөө доор дурдсан шалгууруудын талаар энэ журмын 3.4.8-д заасан баримтад үндэслэн комиссын хурлаар хэлэлцэж, үзүүлэлт тус бүрээр 10 хүртэл оноогоор дүгнэнэ. Үүнд:

6.8.1.хуулийн төсөл, салбарын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;

6.8.2.байгууллагын зорилго, зорилтыг тодорхойлох, хамт олноо манлайлах;

6.8.3.тулгарсан асуудалд дүн шинжилгээ хийж үндэслэл бүхий шийдвэр гаргах.

6.9.Мэдлэг, боловсрол, төрийн албаны мэргэшил, туршлага, мэргэжил, ур чадварын нийлбэр оноогоор хамгийн өндөр оноо авсан 10 оролцогчтой комисс ярилцлага хийнэ. Ярилцлагын дэгийг комисс тогтооно.

6.10.Ярилцлага хийхдээ оролцогчоос төрийн албаны шинэчлэл, хүний нөөцийн бодлогын талаарх оролцогчийн байр суурь болон түүний мэргэжил, ур чадвартай холбогдсон асуулт асууж, 20 хүртэл оноо өгнө.

6.11.Онооны дарааллаар жагсаалт гаргахад нийт оноо тэнцвэл хуулийн төсөл, салбарын болон орон нутгийн хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулахад оролцсон байдал, хийсэн судалгааны ажил, эрдэм шинжилгээний болон бусад бүтээлийг харгалзан эрэмбэлнэ. Эрэмбэлсэн комиссын шийдвэр болон үндэслэлийг холбогдох оролцогчдод танилцуулна.

6.12.Сонгон шалгаруулалтад оролцогч нэр дэвшигчид тавих шаардлагын талаар аливаа хуурамч баримт бүрдүүлсэн болох нь илэрсэн бол түүний сонгон шалгаруулалтын үнэлгээ хүчингүйд тооцогдоно.

**Долоо.Төрийн албан хаагчийн төлөөлөлд санал болгох,  
Улсын Их Хуралд нэр дэвшүүлэх**

7.1.Комисс үнэлгээг эцэслэн нягталж онооны дарааллаар хамгийн эхэнд эрэмбэлэгдсэн оролцогчийн нэр, сонгон шалгаруулалт явуулсан тухай тайлан, холбогдох баримт бичгийг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороонд сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын гурван өдөрт багтаан хүргүүлнэ.

7.2.Төрийн байгуулалтын байнгын хороо комиссын сонгон шалгаруулсан оролцогч Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 68 дугаар зүйлийн 68.2, 68.4, 68.5-д заасан шаардлагыг хангаж байгаа талаар дүгнэлт гарган Төрийн албаны зөвлөлийн гишүүнээр томилуулахаар Улсын Их Хуралд нэр дэвшүүлнэ.

7.3.Хэрэв Төрийн байгуулалтын байнгын хороо нь нэр дэвшигч хуульд заасан шаардлагыг хангахгүй гэж дүгнэлт гаргасан бол энэ тухай үндэслэлийг Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгана. Энэ тохиолдолд дахин нэг удаа онооны дарааллаар дараагийн оролцогчийг энэ журамд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

---оОо---

Монгол Улсын Их Хурлын Төрийн  
байгуулалтын байнгын хорооны 2018 оны 10.  
дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ТӨЛӨӨЛЛИЙН СОНГОН  
ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

VXA0316

Д/д	Оролцогчийн овог нэр*	Мэдлэг, боловсролын түвшний оноо	Төрийн албаны мэргэшил туршлагын оноо	Мэргэжил, ур чадварын оноо	Ярилцлагын оноо	НИЙТ ОНОО
1.						
2.						
3.						
	...					

Жич:

\* - Оролцогчдын нэрийг нийт онооны дарааллаар эрэмбэлнэ.


Комиссийн гишүүн:

Нэр

Гарын үсэг

..... /..... /  
..... /..... /  
..... /..... /  
..... /..... /  
..... /..... /

20... оны ... сарын ... -ны өдөр



БАТАЛГАА

Миний бие ..... /овог нэр/ нь Төрийн албан хаагчийн төлөөллийг сонгон шалгаруулах комисст ажиллахдаа аливаа хөндлөнгийн нөлөөнд авталгүй шударгаар ажиллаж, сонгон шалгаруулах явцаас бусад үед бүртгүүлсэн албан хаагчтай харилцахгүй байх бөгөөд сонгон шалгаруулалтад ашиг сонирхлын зөрчилгүй ажиллахаа баталж байна.

Гарын үсэг /......./

20.. оны ... сарын ... -ны өдөр